

**АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2022.06.15

Эрдэнэт

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ хугацаа	Хугацаа	Хамрах хүрээ	Хүрэх үр дүн, биелэлт хувь
1	2	3	4	5
3.1 Албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах ажлын хүрээнд				
1	Албан хаагчдын компьютерийн мэдээллийн найдвартай, аюулгүй байдлыг хангах шаардлагатай компьютерт вирусээс хамгаалах программ суулгах, шаардлагатай бичгийн хэрэгсэл, ширээ сандал, компьютер принтер болон бусад техник хэрэгсэлээр хангах.	Жилдээ	Байгууллагын ажилчид	Online төвтэй хамтран албан тушаалтангуудын компьютерийн мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор форматлуулж, вирусны хамгаалалт хийлгэн, 1 компьютерт программ уншуулж, гацалтыг арилгасан. Нийт 225,000 төгрөг зарцуулсан байна. Шаардлагатай бичгийн хэрэгслийг сард нь төсвийн дагуу худалдан авч зарцуулсан.
2	Ажилтан, албан хаагчдад сар бүр унаа хоолны мөнгийг "Хөдөлмөрийн дотоод журам"-ын дагуу олгох.	Жилдээ	Байгууллагын ажилчид	Албан хаагчдын өдрийн хоолны мөнгийг сард 3,000 төгрөгөөр, унааны нэмэгдэл хөлс авах ажилчдын нэрсийг шинэчлэн тодорхойлж ажилдаа ирэх, очих автобусны зардлын 50%-ийг хөнгөлж сард 1 хүнд 500 төгрөгөөр тооцон олгож байна. 2022 онд хоол, унааны зардалд 6,629,000 төгрөг олгосон байна.
3	Ажилчдын ээлжийн амралтын батлагдсан хуваарийн дагуу биеэр эдлүүлэх	Жилдээ	Байгууллагын ажилчид	Газрын даргын 2022 оны Б/11 дүгээр тушаалаар ажилчдын энэ оны ээлжийн амралтын хуваарийг батлуулж, хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлж байна. Энэ хугацаанд 7 албан хаагч ээлжийн амралтаа биеэр эдлээд байна.

1	2	3	4	5
4	Гэр хороололд амьдарч байгаа ажилчдыг түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах, орон сууц худалдан авах нөхцөл сайжруулахад нь байгууллагаас дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Байгууллагын ажилчид	Тус байгууллагаас ажилчдаас хөнгөлттэй орон сууцтай болох өргөдөл, хүсэлтийн дагуу аймгийн Засаг дарга С.Батжаргалд 2022 оны 04 дүгээр сарын 13ны өдрийн 01/68 дугаар албан бичгээр хүсэлтийг хүргүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.
5	Баяр, амралтын өдрүүдэд ажилласан албан хаагчдын ажилласан өдрийн ажлын цагийг тооцож нөхөж амраах	Жилдээ	Байгууллагын ажилчид	Жижүүрүүдэд илүү цагийн нэмэгдэл хөлсийг 01-04-р саруудын 3,653,812 төгрөг олгосон байна. 05 дугаар сарын илүү цагийн хөлсийг цалингийн сан хүрээгүй тул 06-р сард нөхөн олгохоор шийдвэрлэсэн.
6	Ажилтныг албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай үед байгууллагын унаагаар хангах	Жилдээ	Байгууллагын ажилчид	Ажилтан албан хаагчдад ажлын хэрэгцээ шаардлага гарсан үед байгууллагаас бензин талон олгож ажилласан. Нийт 5 ажилтанд 1,245,000 төгрөгийн талон олгосон байна.
7	Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулж, үйлчилгээний салбарт ажиллагсдын ажлын хувцас болон үйлчилгээнд шаардагдах материалаар хангах	Жилдээ	Бүх ажилчид	Үйлчилгээний ажилчдад ажлын 16 нэр төрлийн 3,148,400 төгрөгийн материалаар хангасан байна.
8	Байгууллагаас зохиогдсон уралдаан тэмцээнээс бусад тэмцээний үед тухайн байгууллагаас үйлчлэгч, үзелийн ажилласан хөлсийг олгуулах	Жилдээ	Тухайн ажилтанд	Байгууллагаас зохион байгуулж буй тэмцээний төсөвт үйлчлэгч, үзелийн хөлсийг тусган тухай бүр олгосон. Мөн гадны байгууллагаас зохион байгуулагдаж буй тэмцээнд тухай зохион байгуулагчаас өдрийн 20,000 төгрөгөөр тооцон хөлсийг олгуулж байна.
3.2 Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх ажлын хүрээнд:				
1	Албан хаагчдын эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах.	Жилдээ	Бүх ажилчид	"Тавдугаар сарын 1-нээс орон даяар 0-5 болон 18-аас дээш насны бүх иргэдийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах ажил эхэлнэ. Иргэдийг үзлэгт хамруулах график төлөвлөгөө гаргасан, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо бүтэн жилийн турш явагдахтай холбогдуулан албан хаагчдыг тухай бүр ажлаас нь чөлөөлж үзлэгт бүрэн хамруулахаар шийдвэрлээд байна.

1	2	3	4	5
2	Байгууллагын ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор спорт зааланд 7 хоногт 1 удаа 2цаг тоглуулах, нийт ажилчдын дунд спортын арга хэмжээ, цасны баяр, алхалтыг 3-аас доошгүй удаа зохион явуулах	Жилдээ	Бүх ажилчид	Байгууллагын ажилчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор А зааланд 7 хоног бүрийн Лхагва гаригийн 16.00-18.00 цагуудад чөлөөт тоглолтын хуваарийг батлуулж, ажилчдыг бүрэн хамруулж, чийрэгжүүлэлтийг явуулсан. Цасны баяр, явган алхалтыг 10 сар, 12 дугаар сард хийхээр төлөвлөсөн.
3.4 Албан хаагчдад цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, тэтгэвэр олгох, шагнаж урамшуулах ажлын хүрээнд:				
1	Холбогдох хууль тогтоомжийн дагуу албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийг тухай бүр шинэчлэн тогтоох	Тухай бүр	Бүх ажилчид	Даргын 2022 оны А/02 дугаар тушаалаар албан тушаал, үндсэн цалингийн сүлжээ, нэмэгдэл хөлсийг батлуулсан. Засгийн газрын 2022 оны 192 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, даргын 2022 оны Б/21 дүгээр тушаалаар 05-р сарын 01-ний өдрөөс үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг шинэчлэн баталсан.
2	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг улиралд 1 удаа батлагдсан журмын дагуу шалгуур үзүүлэлтээр дүгнэж албан тушаалын 40 хүртэл хувиар олгох	Улиралд 1 удаа	Бүх ажилчдад	Оны эхний хагас жилийн байдлаар албан хаагчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгогдоогүй байна. 2022 оны 02, 03 дугаар сард төрийн үйлчилгээний 12 албан хаагчдад 3,597,141 төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.
3	Албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Засгийн газраас батлагдсан журмын дагуу олгох	Жилдээ	Бүх ажилчид	Албан хаагчдын ажилласан жилийн судалгааг 01-р сард шинэчилэн газрын даргын 2022.01.10-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар ТАХ нэмэгдэлийг сар бүр олгож байна. Эхний хагас жилийн байдлаар 10,278,079 төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна.
4	Гэр болон галлагаатай байшинд амьдардаг 2 хүнд түлээ, нүүрс худалдан авахад нь зориулан батлагдсан төсөвт багтаан 50-100% хүртэл мөнгөн дэмжлэг үзүүлэх.	4-р улиралд	2 ажилтан	Буцалтгүй тусламжийг 12 дугаар сард олгохоор төлөвлөсөн.

1	2	3	4	5
5	Албан томилолтын зардлыг батлагдсан журмын дагуу олгох	Жилдээ	Томилолтоор ажилласан ажилтанд	Эхний хагас жилийн байдлаар 1 албан хаагчид 101,000 төгрөгийн албан томилолтын зардал олгосон байна.
6	Албан хаагч удаан хугацаагаар хүнд өвдсөн, гэр бүлийн гишүүн нь өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болж тэтгэлэг шаардлагатай болсон тохиолдолд эмнэлгийн байгууллагын тодорхойлолт, албан хаагчийн хүсэлтийг харгалзан 1 удаагийн буцалтгүй тусламжийг төсөвт багтаан олгох	Тухай бүр	Тухайн ажилтанд	Мэргэжилтэн О.Жигмэддоржийн гаргасан хүсэлтийн дагуу ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан даргын Б/15 дугаар тушаалаар 150,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.
7	Ажил хавсран гүйцэтгэсэн эзгүй байгаа ажилтны ажлыг давхар гүйцэтгэсэн үед ажилтанд тухайн албан тушаалын цалингаас тооцож 20-40% хүртэл олгох	Жилдээ	Тухайн ажилтанд	мэргэжилтэн Ө.Билэгсайхан, сантехникч-цахилгаанчин Ж.Алтантогос нарт ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40% буюу нийт 2,294,769 төгрөг олгосон байна.
8	Байгууллагын "Ахмадын зөвлөл"-ийг дэмжих хамтарч ажиллах	Жилдээ	Ахмадын зөвлөл	Байгууллагын Ахмадын зөвлөлийн төлөвлөгөөний дагуу Ахмадын баяраар 9 өндөр настанд тус бүр 100,000 төгрөг олгохоор төлөвлөгөөнд тусгасан.
9	Шинэ хүүхэдтэй болсон ажилтанд 7 хоног, төрсөн хүүхэд нь шинэ хүүхэдтэй болсон ажилтанд 3 хоногийн цалинтай чөлөө олгох.	Жилдээ	Тухайн ажилтанд	Нярав Д.Пүрэвзэхүүгийн охин ам бүл нэмж хүүхэдтэй болсон тул ажлын 5 өдрийн цалинтай чөлөө олгосон.
10	Байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийг дэмжиж хамтарч ажиллах	Жилдээ	Эцэг эхийн зөвлөл	Ажилчдын хүүхдүүдийн судалгааг гаргаж Хүүхдийн баяраар 17 ажилтны 29 хүүхэд 880,000 төгрөгийн бэлэг өгсөн байна.
3.4 Албан хаагчийн сургалтын хүрээнд:				
1	Байгууллагын захиалга болон ажилтан, албан хаагч өөрсдийн саналаар мэргэжил эзэмших, мэргэжлээ дээшлүүлэх, өөр мэргэжил эзэмшихээр 3 сар хүртэлх хугацаагаар сургалтанд хамрагдвал холбогдох баримт бичгийг үндэслэн цалинтай чөлөө олгох.	Тухай бүр	Сургалтад хамрагдсан ажилтан	Мэргэжилтэн Б.Энхжаргал МУБИС-ийн биеийн тамирын эчнээ ангид өөрийн хүсэлтээр суралцаж байгаа тул тухай бүр цалинтай чөлөө олгож байна.

1	2	3	4	5
2	Ажилтан, албан хаагч 3 сараас 1 жил хүртэлх хугацаанд сургалтад хамрагдсан тохиолдолд ажилтантай тохиролцож ажлын байр албан тушаалыг нь хэвээр үлдээнэ	Тухай бүр	Сургалтад хамрагдсан ажилтан	Энэ онд 3 сараас дээш хугацаанд сургалтад хамрагдсан ажилтан байхгүй байна.

ХЯНАСАН:
ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ХҮНИЙ
НӨӨЦИЙН АЖИЛТАН



Ч.БОЛДЦЭЦЭГ